*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*6 дугаар хавсралт*

# ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ УЛАМБАЯР ОВОГТОЙ ОТГОНБАЯРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх”** | | | | | | | |
| 1. | Гаалийн хяналтад эрсдэл тооцсон байдал:<br>- Эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн дүн шинжилгээ хийж үр дүнг тооцсон байна.<br>- Өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийнэ. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | 1.1 2025 оны 01-05 дугаар сарын гаалийн байгууллагын системийн хэмжээний болон харьяа газар, хороодод хийгдсэн гаалийн бүрдүүлэлтийн хяналтын “Ногоон”, “Улбар шар” болон “Улаан” төлөвд сонгогдсон мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, тайлагнасан (мэдээ, мэдээллийг дараах үзүүлэлтийн дагуу гаргасан, үүнд, “1. Хяналтын “Ногоон”, “Улбар шар”, “Улаан” төлөвд сонгогдсон импортын болон экспортын мэдүүлгийн тоогоор”, “2. Гаалийн бүрдүүлэлтийн тоо-эрсдэлийн шалгуурын дагуу”, “3. Гаалийн хяналтын төлөвийн бүтэц, хувиар”, “4. “Ногоон” болон “Улбар шар” хяналтын төлөвийн импортын, экспортын бүрдүүлэлтийн мэдээ”, 5. Нийт бүрдүүлэлт дэх гаалийн мэдүүлгийн засварт буцаалтын тоо, “баталгаажихаас өмнө” болон “баталгаажсаны дараа”, 6. Гаалийн мэдүүлгийн төлөвийн өөрчлөлт, импорт-экспортын мэдүүлгээр).<br>1.2 ГЕГ-ын сар тутмын “Захиргааны статистик мэдээлэл (Дотоод хэрэгцээнд)” сэтгүүлийн 2025 оны 01-05 дугаар сарын дугаарт өгөх “3-ГМ-Маягт 18” буюу “ХЯНАЛТЫН ТӨЛӨВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ 2 САРЫН МЭДЭЭ, МЭДҮҮЛГИЙН ТООГООР, өссөн дүнгээр” хавсралт мэдээллийг гаргаж, Статистик, дүн шинжилгээний хэлтэст цахимаар хүргүүлсэн.<br>1.3 “Монгол Улсын Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн “Дугаар: 06” тоот “Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтаар батлагдсан “Гаалийн ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-ийн “Гурав. Агентлагийн бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үндсэн үүрэг, чиг үүрэг”-ийн хэсэгт заасны дагуу “Замын-Үүд гаалийн газрын Мэдээллийн технологийн өнөөгийн тогтолцоо”-нд эрсдэлийн судалгаа, дүн шинжилгээг хийж байна (Замын-Үүд ГГ-ын “Мэдээллийн технологи”-ийн асуудал | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хариуцсан мэргэжилтэн, албан хаагчдад ногдож буй ажлын ачаалал, гаалийн газрын компьютер, зөөврийн нөүтбүүкийн техник-программ хангамжийн ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын эрсдэлийн судалгаа).<br>1.4 Гаалийн ерөнхий газрын "2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө"-ний "1.2.Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хэрэгжилтийг хангах (Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой одоогийн хэрэглэж буй программ хангамжийн талбар тус бүрээр давуу, болон сул талыг гарган, цаашид сайжруулах арга хэмжээний санал гаргах;)" хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Мэдээллийн технологийн газарт Эрсдэлийн удирдлагын хэлтсийн "Дугаар: 01800/91" тоот дотоод зурвасаар хүргүүлсэн, үүнд, "2013-2024 оны хооронд "Эрсдэлийн удирдлага"-ын асуудал хариуцсан ГУАБ, ГУБ-аар ажиллаж байсан зарим хэрэглэгч нарын CAIS (КАЙС буюу Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем)" системийн Эрсдэлийн удирдлагын программд нэвтрэх эрхийг хасуулах нэрсийн жагсаалт", "КАЙС системийн "Эрсдэлийн удирдлагын программ"-ын засч залруулах зарим алдааны жагсаалт" болон "ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Дарга, ГАУБ, ГУБ, харьяа гаалийн газар, хорооны дарга, "Эрсдэлийн удирдлага"-ын асуудал хариуцсан албаны дарга, салбарын эрхлэгч, ГУАБ, ГУБ нарын CAIS системд ажиллах эрхийн жагсаалт"-ыг гаргаж хүргүүлсэн.<br>1.5 Өөрийн хариуцсан газар хорооны эрсдэлийн профайл, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн баяжилтыг хийх ажлын хүрээнд:<br>-Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын "Эрсдэлийн удирдлага"-ын асуудал хариуцсан ГУБ Айнагүлтэй холбогдож, Цагааннуур боомтоор "нефть бүтээгдэхүүн импортлогч "Эн Пи Петролиум", "Хөрс авто сервис", "Хазына ХХКомпани" зэрэг аж ахуйн нэгжийн гаалийн бүрдүүлэлтийн төрөлжсөн судалгаа"-г хийж, "Эрсдэлийн шалгуурын хүсэлт"-ийг хамтран боловсруулахаар судалгааг хийж байна.<br>*Хүрсэн үр дүн:*<br>· *Судалгааны үр дүн болон ГЕГ-ын БЦТ, БДШГ, харьяа гаалийн газар, хороодтой хамтран ажиллаж, КАИС-ийн ЭУП-д тайлант хугацаанд 62 хяналтын хуудсаар нийт 587 эрсдэлийн шалгуур боловсруулж, батлуулан, оруулсан.*<br>· *Эрсдэлийн удирдлагад суурилсан үр дүнгээр БДШГ-т 36 ААН-ийн мэдээллийг хүргүүлж, үйл ажиллагааны уялдаа холбоог хангаан ажилласан. БДШГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 11-ны өдрийн 01/32, 01-6/12, 01-6/18 дотоод зурвасаар ирүүлсэн бүрдүүлэлтийн дараах шалгалтад хамрагдсан 71 ААН-д эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, эрсдэлийн удирдлагын программд оруулсан.* | | |
| 2. | Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах: | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | · Тайлант хугацаанд 42,273 гаалийн мэдүүлгийг засварт буцаасан нь нийт бүрдүүлэлтийн 9.2%-ийг эзэлж байна. Үүнд: 38,469 мэдүүлгийг баталгаажихаас өмнө, 3,804 мэдүүлгийг баталгаажсаны дараа тус тус засварт буцаасан байна. | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Өөрийн хариуцсан газар хорооны хяналтын төлөвийн хэрэгжилт, төлөв солилтын шалтгаан үр дүнг тооцно. | | | | · Гаалийн хяналтын ногоон төлөвт сонгогдсон 15, улбар шар төлөвт сонгогдсон 10, нийт 25 гаалийн мэдүүлгийн төлөвийг өөрчилсөн байна.<br>· Нийт АПИС-ийн мэдээллээр 635,912 зорчигч бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.7 хувиар өссөн.(635,912/606,790).<br>· Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын “Эрсдэлийн удирдлага”-ын асуудал хариуцсан ГУБ Айнагүлтэй холбогдож, Цагааннуур боомтоор “нефть бүтээгдэхүүн импортлогч “Эн Пи Петролиум”, “Хөрс авто сервис”, “Хазына ХХКомпани” зэрэг аж ахуйн нэгжийн гаалийн бүрдүүлэлтийн төрөлжсөн судалгаа”-г хийж, “Эрсдэлийн шалгуурын хүсэлт”-ийг хамтран боловсруулахаар судалгааг хийсэнж байна.<br>· Дорнод ГГ, Баян-Өлгий ГГ, Ховд аймгийн Булган дахь ГГ, Увс ГГ болон Сайншанд ГГ зэрэг харьяа гаалийн газрын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг 2025 оны 06 сарын 15-аас хойш үнэлнэ.<br>*Хүрсэн үр дүн:*<br>*Бичиг баримтын болон бараанд хийх шалгалтаас нийт гаалийн бүрдүүлэлтийн 60%-ийг чөлөөлсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь экспортын гаалийн бүрдүүлэлт буурсантай холбоотой.*<br>· *Зорчигчийн мэдээллийн санд 112 зорчигч бүртгэгдсэн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна (112/58). Шалгалтын үр дүнд 2,047 зорчигчийг онилж шалган, 42 хууль бус эм, эмнэлгийн хэрэгсэл, мансууруулах бодис, алт монетан эдлэл, татвартай бараа зэрэг хууль бус үйлдлийг таслан зогсоож, хариу арга хэмжээг авсан байна.* | | |
| 3. | Гадаад худалдааг хөнгөвчлөх:<br><br>Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийг сурталчлан, таниулах арга хэмжээнд оролцох. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | - ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн I хэсгийн 12 зүйлийн хүрээнд тодорхойлсон 36 арга хэмжээ тус бүрээр хэрэгжилтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар гарган гаалийн албан хаагчдын хүртээл болгохын зэрэгцээ Худалдааг хөнгөвчлөх үндэсний хороо, СЯ, ГХЯ-нд хүргүүлж, мэдээллийн ил тод нээлттэй байдлыг хангаж ажилласан.<br>- 2025 онд хэрэгжилтийг хангах үүрэг амлалт авсан “Зүйл 3. Барааны урьдчилсан шийдвэр, Зүйл 10.3 Олон улсын стандарт ашиглах” арга хэмжээний хэрэгжилтийг ГХЯ ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хороонд хүргүүлж Монгол Улсын хэлэлцээрийн өмнө хүлээсэн үүрэг амлалтыг биелүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.<br>- ДГБ-ын “Меркатор” хөтөлбөрийн хүрээнд Монголын гаалийн байгууллагын худалдааг хөнгөвчлөх үйл ажиллагаанд хийсэн онош зүйн шинжилгээний тайланд туссан 16 зөвлөмжийн хүрээнд боловсруулсан 56 арга хэмжээ бүхий дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтийн мэдээллийг нэгтгэн, ГЕГ-ын ЗБББНДБ-д дотоод зурвасаар хүргүүлж, нэгдсэн тайланг гаргалаа.<br>- Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн зарим заалтын хэрэгжилтийг тусгасан тайланг Үндэсний хороонд тайланг бэлтгэн, СЯ, ГХЯ, ЭЗХЯ-нд хүргүүлэв.<br>- НҮБ-ын (ХХБХ)-ын “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч” системд 27 арга хэмжээний хэрэгжилт, бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны гишүүдийн уялдаа холбоог хангаж, уг системд нэвтрэх чиглэлээр сургалт | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зохион байгуулж, ГЕГ-ын ЗББНДБ, харьяа гаалийн газар, хороодын 34 шинэ хэрэглэгчийг уг системд бүртгэн, үйл ажиллагааг идэвхжүүлсэн.<br>*Хүрсэн үр дүн:*<br>*2025 онд ДГБ, ДХБ, НҮБ-ын ХХБХ, ОУВС, СЯ, ГХЯ, ЭЗХЯ, Европын Холбооны “Монгол Улсын гадаад худалдааг хөгжүүлэх төсөл” болон ГЕГ-ын харьяа нэгж, худалдаа эрхлэгчидтэй 5 албан бичиг, 73 цахим захидал солилцож, 21 уулзалт, 3 сургалтыг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулсан. Мөн Гаалийн байгууллагын цахим хуудас болон НҮБ-ын ХХБХ-ын “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч” программд 15 мэдээлэл бэлтгэн нийтэлж, олон нийтийн хүртээл болгосон.*<br>· *ДХБ-ын Худалдааг хөнгөвчлөх хэлэлцээрийн I хэсгийн 12 зүйлд хамаарах 36 арга хэмжээний хэрэгжилтийн дэлгэрэнгүй мэдээллийг ГХЯ-д хүргүүлж, хэлэлцээрийн хэрэгжилтийн түвшинг 86.4%-аас 95.2% болсон.*<br>· *НҮБ-ын ХХБХ-ын “Худалдааг хөнгөвчлөх шинэчлэлийн хөтөч” системд 27 арга хэмжээний хэрэгжилт болон бусад мэдээллийг оруулж, Үндэсний хорооны уялдаа холбоог хангаж хэрэгжилтийг 79%-аас 83.02% болсон.*<br>· *Тус системд Монгол Улсаас 78 хэрэглэгч бүртгэгдэж, 44 гаалийн хэрэглэгч идэвхтэй ажилласан. 43 үүрэг, 11 мэдээллийг системд оруулж, 729 удаа өөрчлөлт хийж, 8,265 удаа хандалт хийсэн нь ил тод байдлыг нэмэгдүүлсэн. ДГБ-ын “Меркатор” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын худалдааг хөнгөвчлөх дунд хугацааны төлөвлөгөөний хэрэгжилтээр 57%-иас 80.7% болж, “Дийлэнх арга хэмжээг хэрэгжүүлсэн” буюу 3 дугаар түвшинд хүрсэн.* | | |
| 4. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт:<br>- Гаалийн хяналтад эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор “Гаалийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулахад санал боловсруулж, хамтран ажиллана.<br>- Эрсдэлийн удирдлагын чиглэлээр холбогдох бусад бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр тайлагнасан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | - Гаалийн ерөнхий газрын “2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний “1.2.Гаалийн хяналтад эрсдэл тооцох ажлын хэрэгжилтийг хангах (Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой одоогийн хэрэглэж буй программ хангамжийн талбар тус бүрээр давуу, болон сул талыг гарган, цаашид сайжруулах арга хэмжээний санал гаргах;)” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Мэдээллийн технологийн газарт Эрсдэлийн удирдлагын хэлтсийн “Дугаар: 01800/91” тоот дотоод зурвасаар хүргүүлсэн, үүнд, “2013-2024 оны хооронд “Эрсдэлийн удирдлага”-ын асуудал хариуцсан ГУАБ, ГУБ-аар ажиллаж байсан зарим хэрэглэгч нарын CAIS (КАЙС буюу Гаалийн мэдээллийн автоматжуулсан систем)” системийн Эрсдэлийн удирдлагын программд нэвтрэх эрхийг хасуулах нэрсийн жагсаалт”, “КАЙС системийн “Эрсдэлийн удирдлагын программ”-ын засч залруулах зарим алдааны жагсаалт” болон “ГЕГ-ын Эрсдэлийн удирдлагын хэлтсийн Дарга, ГАУБ, ГУБ, харьяа гаалийн газар, хорооны дарга, “Эрсдэлийн удирдлага”-ын асуудал хариуцсан албаны дарга, салбарын эрхлэгч, ГУАБ, ГУБ нарын CAIS системд ажиллах эрхийн жагсаалт”-ыг гаргаж хүргүүлсэн.<br>- Хар тамхи, мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн “Дугаар: 412” тоот дотоод зурвасаар ирүүлсэн “Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн “Хөтөлбөр батлах тухай” 265 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр” болон Хууль зүй, дотоод хэргийн сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 9-ний өдрийн А/04 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - | | | | санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 149 дэх ажил (Хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хяналт шалгалтын давхардлыг арилгах, улмаар хуульд заасан 15 сая төгрөгөөс доош хэмжээгээр гаальд мэдүүлээгүй олон давтамжтай нэвтэрч буй зорчигчдын хөдөлгөөнд авах арга хэмжээг тодорхой болгох)-ыг эрчимжүүлж, төлөвлөгөөний биелэлт, хэрэгжилттэй холбоотой холбогдох мэдээлэл, саналыг ирүүлэхийг хүссэн”-тэй танилцаж, саналыг боловсруулж, ЭУХ-ийн “Дугаар: 01800/97” тоот дотоод зурвасаар хүргүүлсэн байна.<br>- Захиргааны удирдлагын газрын 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн “Дугаар: 01100/47” тоот дотоод зурвасаар ирүүлсэн “Гаалийн байгууллагын 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 1.2, 1.3 дахь арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд иргэд, олон нийтэд гаалийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааг сурталчлах, авлигын хор хөнөөлийг ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулах, түүнд уриалсан мэдээлэл түгээх зорилгоор хэвлэмэл материал, гарын авлагыг гаргаж, иргэн, аж ахуйн нэгжийн төлөөлөлд тараан ажиллахаар зорьж байна. Иймд гарын авлага, хэвлэмэл материалын эх загварыг гаргаж, 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлж ажиллах”-тай танилцаж, А4 форматаар 2 нүүр материалыг бэлтгэж, хариуг хавсралтаар хүргүүлэв.<br>*Хүрсэн үр дүн:*<br>· *Гаалийн хяналтыг хэрэгжүүлэх журамд “Зорчигч, улс хоорондын шуудан илгээмжид эрсдэл тооцох” чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, сүүлийн хагас жилд КОЙКА-ийн төслийн хүрээнд хэрэгжүүлэх автоматжуулалттай уялдуулах боломжийг бүрдүүлсэн.*<br>*Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын үр нөлөөг үнэлэхдээ экспорт, импортоор ялган, гаалийн мэдүүлэг, барааны бичлэг, статистик дүн, татварын дүн болон эрсдэлийн шалгуурын үр нөлөөг тооцох эхлэлийг тавьсан.* | | |
| 5. | Үүрэг даалгаврын биелэлт:<br>- Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн байна.<br>- Хариуцсан гаалийн газар, хороодод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 60% | ***Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь бүрэн биелүүлсэн:***<br>- АХБ-ны санхүүжилтээр “Хилийн үйлчилгээг сайжруулах бүс нутгийн төсөл”-ийн “Хилийн боомтуудад ухаалаг гарцыг нийлүүлж, хэрэгжүүлэх” ажлын хүрээнд ГЕГ-ын дарга Р.Отгонжаргал болон Санхүүгийн Мэдээллийн Төвийн Улсын үйлдвэрийн газрын захирал Т.Батбилэг нарын хамтран баталсан “Ухаалаг гарц системд Эрсдэлийн тооцоолол оруулах төлөвлөгөө”-нд заасны дагуу “Ухаалаг гарц”-ын Автотээврийн хэрэгсэлд эрсдэл тооцох программ хангамжийн алгоритмыг боловсруулж, Хяналт, бүрдүүлэлтийн газарт хүргүүлсэн болно.<br>- ЭУХ-ийн 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн “Дугаар: 02-1.1/316” тоот албан бичигт “3.Гаалийн хяналтын орчин үеийн тоног төхөөрөмжөөр гаалийн хяналтыг үр дүнтэй зохион байгуулахтай холбоотой судалгааг 03 дугаар сарын 28”-ны хийж ирүүлэх үүрэг даалгаврыг ГЕГ-ын харъяа гаалийн газар, хороодод хүргүүлсэн байна. Үүрэг даалгаврын биелэлтийг Улаанбаатар ГГ, Замын-Үүд ГГ, Сэлэнгэ ГГ, Чингис Хаан ОУНБ ГГ, Дорнод ГГ, УХШИГГ, Дархан ГГ, Бичигт ГГ болон Хөвсгөл ГХ зэрэг газар, хороодоос ирүүлснийг нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн. | 2025.01.02-2025.06.10 | 100% |

- ГЕГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр баталсан "Татварын орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийг хангах ажлын төлөвлөгөө"-ний дагуу судалгаа, дүн шинжилгээ болон сурталчилгааны материалыг бэлтгэж хүргүүлсэн.
- СЕРП-ийн "Үүрэг даалгавар": Зөвлөмж ХШҮДАГ-ын 11; Цаг үеийн шинжтэй ЗУГ-ын нэг үүрэг даалгаврын биелэлтийг хангаж ажилласан.
- Бичиг хэргийн e.doc программд бүртгэгдэж, ирсэн 29 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж, 13 дотоод зурвасыг ЗББНДБ-уудад хүргүүлж, хамтран ажилласан.
- ГЕГ-ын ХНХ, ЗУГ, ҮААА, Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан цахим санал асуулгад тухай бүр оролцсон.

***Хариуцсан гаалийн газар, хороодод хүргүүлсэн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь дүгнэж, ЗДАС программд үнэлсэн байна.***
Өөрийн хариуцаж ажилладаг харьяа гаалийн газарт (Дорнод ГГ, Баян-Өлгий ГГ, Ховд аймгийн Булган дахь ГГ, Увс ГГ болон Сайншанд ГГ) ЭУХ-ээс өгсөн 4 үүрэг даалгаврын биелэлттэй танилцаж, арга зүй зөвлөмжөөр хангаж, дүгнэсэн.

***Сургалт, зөвлөгөөн:***
- БНСУ-ын консорциумаас "хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэд технологийг нэвтрүүлэх замаар монголын гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл"-ийн уулзалтад оролцсон.
- ГЕГ-ын даргын 2025.04.16-ны өдрийн А/152 дугаар тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулах судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсэг"-ээс зохион байгуулсан "Мэдээллийн дүн шинжилгээ" Power BI сургалтад хамрагдсан.

Тайлант хугацаанд 8 удаагийн мэдээллийн цагаар дараах 11 сэдвийн хүрээнд хамрагдсан. Үүнд:

-"Сэдэв.Гаалийн улсын байцаагчийн сэтгэл зүйн эрүүл мэнд", Илтгэгч Ч.Мөнххишиг (ГЕГ-ын Сургалтын төвийн дарга);
-"Сэдэв. Зорчигчийн мэдээллийн төв", Илтгэгч Б.Нямдаваа (ЗМТ-ийн Дүн шинжилгээний хэлтсийн ажилтан); "Сэдэв.Эрүүл зөв хооллолт, сахарын хор уршиг", Илтгэгч эмч Дугархүү (ЗУГ, МТГ, 2025 оны 03 дугаар сарын 14);
-"Сэдэв.Даатгал бидний амьдрал", Илтгэгч В.Амарбаяр (Монгол даатгал ХК-ийн Ахлах андеррайтер), (ЗУГ, МТГ, 2025 оны 03 дугаар сарын 21);
-"Сэдэв.Соёлын өвийн үндэсний төвийн үйл ажиллагаа", Илтгэгч Г.Анхсанаа (СӨҮТ-ийн Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газрын дарга), "Сэдэв. Мэдээллийн аюулгүй байдал", Илтгэгч "И-Монгол академи" УТҮГ-ын Сургалт, олон нийттэй харилцах газрын Сургалтын хэлтсийн Сургалт хариуцсан мэргэжилтэн К.Ломбодорж, сургагч багш Х.Тайванцэцэг нар, (ЗУГ, МТГ, 2025 оны 04 дугаар сарын 04);
-"Сэдэв. АНУ-ын ерөнхийлөгч Д.Трампын бодлого ба олон улсын зах зээлийн хандлага", Илтгэгч В.Энхболд (Онц бөгөөд бүрэн эрхт төлөөлөгч, (Ph.D)), "Сэдэв. Жижиг нээлттэй эдийн засгийн худалдааны бодлогын загвар ба тарифын зохицуулалт, анхаарах асуудлууд", Илтгэгч Н.Батнасан (МУИС-ийн

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Бизнесийн сургуулийн захирал, (Ph.D)), (ЗУГ, МТГ, 2025 оны 04 дүгээр сарын 25);<br>-"Сэдэв. ФАТФ-ын Монгол Улсын дараах харилцан үнэлгээ хийхэд гаалийн байгууллагын оролцоо", ГЕГ-ын Зөрчилтэй тэмцэх газраас Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албаны ахлах шинжээчтэй хамтран зохион байгуулсан, (ЗУГ, МТГ, 2025 оны 05 дугаар сарын 02);<br>-"Сэдэв.Жендэр ба бодлого төлөвлөлтийн тухай", Илтгэгч Амгалан (Жендерийн үндэсний хорооны техникийн зөвлөх), (ЗУГ, МТГ, 2025 оны 05 дугаар сарын 30);<br>- 2025 оны 05 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулсан Монгол Улсын ГЕГ болон БНСУ-ын консорциумаас хэрэгжүүлэх "Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх" гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төслийн зөвлөгөөн, уулзалтад оролцсон.<br>- Хэлтсийн 2025 оны 02 дугаар сарын бичиг хэргийн ажлыг хариуцан ажилласан. | | |
| 6. | Байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэх:<br><br>Гадаад орнуудтай Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийг харилцан хүлээн зөвшөөрөх чиглэлээр байгуулсан хэлэлцээр, бусад баримт бичгийн хэрэгжилтийг хангах ажилд хамтран ажилласан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | · ИААН хөтөлбөрийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор үндэсний үйлдвэрлэл эрхлэгч 15 ААН-д урилга хүргүүлж, хөтөлбөрийг сурталчлан, 5 ААН-д удирдамжийг батлуулж, 2 ААН-ийн ажлын байрны үнэлгээ, баталгаажуулалтыг хийж, Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанд танилцуулах бэлтгэл ажлыг хангасан.<br>· Гадаад орны гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хүрээнд БНХАУ-ын ГЕГ-тай байгуулсан хэлэлцээрийг албан ёсоор эхлүүлж, хоёр орны Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан ААН 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс талуудын импортын бүрдүүлэлтэд хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлсэн.<br>· ОХУ, Беларусь, Хонг-Конгийн Гаалийн байгууллагатай ИААН-ийг харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулах идэвхтэй хамтын ажиллагааг хөгжүүлж эхэлсэн. | 2025.01.02-2025.06.10 | 100% |
| 7. | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт:<br><br>Буцалтгүй тусламж, зээл, техникийн туслалцааны төслүүдээр дамжуулан Эрсдэлийн удирдлагын систем, тогтолцоог сайжруулах, дэвшилтэт технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах, төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлыг | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 30% | - -ГЕГ-ын дэргэдэх МТГазарт ЭУХ-ийн "Дугаар: 01800/101" тоот дотоод зурвасаар "КАЙС системийн "Эрсдэлийн удирдлага"-ын программын "Нүүр хуудас (Эрсдэлийн удирдлага) -> Эрсдэлийн шалгуурын судалгаа -> Сонгон шалгалт ->Төлөвийн мэдээ (тухайн талбараас "1.Төлөвийн мэдээ, харьяа гаалийн газар, хороодоор"; "2.Мэдүүлгийн засвар буцаалтын мэдээ, баталгаажсаны өмнө, баталгаажсаны дараа"; "3.Төлөвийн мэдээ, системийн хэмжээнд" зэрэг үзүүлэлтээр мэдээ, мэдээллийг гаргаж, гаалийн байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг)"-ний талбарт гарч буй зарим алдааг засч залруулах саналыг хүргүүлсэн.<br>- "Монгол Улсын Гаалийн Ерөнхий газрын Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа болон агаарын тээврийн зорчигчийн дагалдах ачаанд тавих гаалийн хяналтыг ахисан түвшинд хүргэх төсөл"-д хамрагдах хүсэлтийг МТГ-тай хамтран 2023 онд БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА)-д хүргүүлж, 2023, 2024 онд Техник, эдийн засгийн | 2025.01.02-2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэрэгжүүлэхэд хамтран ажилласан байна. | | | | үндэслэлийн судалгаа хийж уг төсөл 2025-2028 онд 5.6 сая ам. долларын өртөгтэй хэрэгжихээр болсон.<br>- Монголын Гаалийн байгууллага БНСУ-ын "Шинжлэх ухаан, мэдээлэл, харилцаа холбооны технологийн яам"-ны "Хиймэл оюунд суурилсан дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар Монголын Гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл"-д хамрагдах хүсэлтээ илэрхийлсэн.<br>- БНСУ-ын Мэдээллийн технологийн консерцум (Data Innovator For a Better World B2EN Co.,Ltd) төслийг 2025-2026 онд хэрэгжүүлэхээр болж, хамтран ажиллах төлөвлөгөөнд гарын үсэг зурж, Сангийн яамаар уламжлуулан цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр ажиллаж байна. Энэхүү төсөл хэрэгжсэнээр "Хиймэл оюунд суурилсан үйлчилгээний багц болон Нейрон процессортой (NPU) серверүүд нь судалгаанд суурилсан шийдвэр гаргалтыг сайжруулах, гаалийн бүрдүүлэлтийн үйл явцыг оновчтой болгох, эрсдэлийн удирдлагын системийг сайжруулах, хүнээс хамааралтай үйл ажиллагааг цахимжуулах, хууль ёсны худалдааг хөнгөвчлөх арга хэмжээг шинэ шатанд гаргах болно. | | |
| **Зорилт 3. "Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх"** | | | | | | | |
| 8. | Хууль тогтоом, тогтоомж, тогтоол шийдвэр, эрхзүйн актын хэрэгжилт:<br>- Хөрөнгө орлогоо мэдүүлбэл зохих төрийн тусгай албан хаагчийн ХАСХОМ-ийг мэдүүлсэн тухай баталгааны маягтыг хуулийн хугацаанд гаргана.<br>- Нэгжийн чиг үүргийн хүрээний өөрт хамаарах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг хийж, цаг хугацаанд нь тайлагнасан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | 100% | 100% | Хууль тогтоомжид заасны дагуу Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн системээр 2024 оны ХАСХОМ буюу Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахимаар мэдүүлж, баталгаажуулж дуусcан. | 2024.01.02-2024.06.10 | 100% |
| 9. | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал:<br>- Нэгжийн эрсдэлийг таньж тогтоож сан үүсгэхэд өөрийн чиг үүрэгт хамаарах ажлыг хийсэн байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | Нэгжийн гүйцэтгэлийг давхардалгүй, орхигдуулахгүй, үр дүнтэй зохион байгуулахад учирч болзошгүй эрсдэлийг таньж, тогтоон түүнийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд "Эрсдэлийн удирдлагын хэлтсийн үйл ажиллагааны эрсдэлийн дүн шинжилгээ"-г хийхэд оролцсон. Эрсдэлийн дүн шинжилгээг ДГБ-ын "Эрсдэлийн удирдлагын компендиум", Олон улсын стандартын байгууллагын "Эрсдэлийн удирдлагын зарчим ба стандарт", холбогдох үндэсний хууль тогтоомжтой уялдуулан хийж гүйцэтгэсэн.<br>- *Дотоод зохион байгуулалт:* Нэгжийн төлөвлөгөө, тайлан гаргах үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг бууруулах зорилгоор албан хаагчид сар бүр хуваарийн дагуу бичиг хэрэг, тайланг хариуцаж, улирал, хагас | 2024.01.02-2024.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | - Эрсдэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийхэд удирдлагаас өгсөн ажлыг хийсэн байна. | | | | жил, бүтэн жилд ГУАБ, дарга хамтран тайланг нэгтгэн, хөдөлмөр зохицуулалтын хуваарилалт хийж, хэрэгжилтийг хангаж байна.<br>- *Хүний нөөц:* Тус хэлтэст ажиллах хүний нөөцийн дутагдалтай байдлыг бууруулах зорилгоор ГЕГ-ын дарга, ХНХ-т танилцуулж, харьяа гаалийн газар, хороодын эрсдэлийн удирдлага хариуцсан албан хаагчдыг ГЕГ-т ажиллах хуваарийг гаргасан.<br>- *Мэдээллийн технологи:* ЭУХ-ийн суурин компьютер, принтерийн ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлын эрсдэлийн судалгаа хийж “Эрсдэлийн удирдлагын систем болон бараа сонгон шалгах үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх төсөл (2025-2027 он)”-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой үүсэж болзошгүй эрсдэл, хэрэгцээ, шаардлагын талаар СХОГ-т 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 01800/12 Дотоод зурвасаар хүргүүлсэн.<br>- Хэлтсийн албан хаагчид ажлын уялдаа холбоог хангаж, чиг үүргийн зарим ажил орхигдох эрсдэлийг бууруулсан. Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удирдах төв байгууллага болон харьяа гаалийн газар, хороодын хооронд ажлын уялдаа холбоогүй байх эрсдэлийг бууруулж, нэгдсэн зохицуулалттай эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг сайжруулсан.<br>- Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангахад багаар ажиллахад дэмжлэг үзүүлж Ухаалаг дэлгэцийг тус хэлтэст хуваарилсан нь, ажлын уялдаа холбоог хангаж, цаг хэмнэсэн үр дүнд хүрсэн. | | |
| 10. | Ажлын цаг ашиглалт:<br>Тухай бүр нүүр таних программд бүртгүүлж, ажлын шаардлагаар илүү цагаар ажилласан цагийг гүйцэтгэлээр баталгаажуулсан байна. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | Тайлант хугацаанд өглөө орой бүр цаг бүртгэлийн нүүр таних төхөөрөмжид бүртгүүлж, уулзалт зөвлөгөөн, хэлэлцүүлэгт оролцсон үед чөлөө авах хүсэлтийг CERP-д тухай бүр оруулж, ажлын цаг ашиглалт тасалдалгүй болно (Ажлын 112 өдөр буюу 896 цаг ажилласан. Цаг ашиглалт 100%. Чөлөөтэй цаг: 26 цаг; Илүү цаг: 11859 мин буюу 24.6 хүн/өдөр – 2025.01.02-2025.06.10-ны өдрөөр) | 2024.01.02-2024.06.10 | 100% |
| 11. | Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байдал:<br>- Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байна.<br>- Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээ, | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | - Тус хэлтсээс 2025 оны 01 сарын 21-ний өдрийн “Ажлын чиглэл хүргүүлэх тухай” 02-1.1/316 дугаар албан бичгээр “Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын стратеги”-ийн 2.1.4, 2.2.3, 2.2.4 дэх заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд 2023, 2024 онтой харьцуулж, 3 чиглэлээр судалгаа, дүн шинжилгээ хийх чиглэлийг хүргүүлсэн. Гэвч ГСГГ, ШИГГ-аас ирүүлсэн судалгаа дээр дурдсан чиглэлийн дагуу хийгдээгүй, шаардлага хангаагүй тул судалгаа хийж ирүүлэх талаар албан бичиг (02-1.1/1702, 02-1.1/1703) хүргүүлсэн.<br>- Тус хэлтэс нь 2025 оны 5 сарын байдлаар харьяа гаалийн газар, хороодод 7 үүрэг даалгавар хүргүүлсэн ба хэрэгжилтийг ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалаар батлагдсан аргачлалын дагуу бодитой үнэлж, дүгнэж ажилласан.<br>- Ажлын хэсгийн болон төлөвлөгөөт бус бусад чиг үүргийн дагуу тус хэлтэс нь 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар нийт 6 ажлын хэсэг, хороодод орж ажилласан. | 2024.01.02-2024.06.05 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан байдлыг тайлагнасан байна. | | | | - Хүрсэн үр дүн: 14 ажлын хэсгийн 5 ажлын хэсэгт оролцож, үр дүнг гаргасан. Бусад ажлын хэсэгт арга зүй, зөвлөмжөөр хангасан.<br>ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө (Нэг.Сургалтын төвөөс зохион байгуулах сургалт)-нд тусгагдсан ажлын хүрээнд дараах сургалтанд хичээл заасан байна, үүнд:<br>1.“ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө (Нэг.Сургалтын төвөөс зохион байгуулах сургалт)”-ний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр Сургалтын төвд зохион байгуулагдсан “Гаалийн улсын байцаагч” нарыг "Барааны ангилал, гаалийн тариф татвар, гаалийн үнэ, үнэлгээ"-ний чиглэлээр чадавхжуулах дунд шатны мэргэшүүлэх сургалтын үеэр “Гаалийн бүрдүүлэлттэй холбоотой эрсдэлийн дүн шинжилгээ”-ний хичээлийг зааж, “Бичиг баримтын хяналт хариуцсан ГУБ, Хяналт, шалгалт хариуцсан ГУБ болон Хорио цээрийн хариуцсан ГУБ нарын шалгалтын үр дүнгийн санал оруулж буй сайн туршлага, дутагдалтай тал хүндрэл” сэдвээр асуулт-хариулт хэлбэрээр харилцан ярилцсан ("Барааны ангилал, гаалийн тариф татвар, гаалийн үнэ, үнэлгээ"-ний асуудал хариуцсан 25 ГУБ оролцсон).<br>2.“ГЕГ-ын 2025 оны сургалтын төлөвлөгөө (Нэг.Сургалтын төвөөс зохион байгуулах сургалт)”-ний дагуу 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Сургалтын төвд зохион байгуулагдсан “Гаалийн хорио цээрийн асуудал хариуцсан ГУБ нарын мэргэшүүлэх сургалт"-ын “Гаалийн эрсдэлийн удирдлагын менежмент (Хууль сахилтын эрсдэлийн удирдлага)” сэдвээр хичээл зааж, гаалийн байгууллагын CAIS системийн “Эрсдэлийн удирдлагын программ”-д ашиглаж буй эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдийг Засгийн газрын 2014 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Импортын барааны эрсдэлийг тодорхойлох шалгуурууд”-тай хэрхэн уялдуулах талаар асуулт-хариулт хэлбэрээр харилцан ярилцлагыг өрнүүлсэн ("Гаалийн хорио цээр"-ийн асуудал хариуцсан 20 ГУБ оролцсон).<br>3.ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвд зохион байгуулагдаж буй “Гаалийн хэргийн анхан шатны мэдлэг олгох чиглүүлэх сургалт”-ын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасны дагуу 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр “Гаалийн эрсдэлийн удирдлага” болон “Гаалийн итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр” сэдвээр тус тус нэг цагийн хичээл заасан (“1.Гаалийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, 2.Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын схем, 3.Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт, 4.Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийн хэрэгжилт” зэрэг илтгэл-танилцуулга).<br>4.ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвд зохион байгуулагдаж буй “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх сунгах давтан шатны сургалт”-ын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасны дагуу 2025 оны 05 дугаар сарын 16-ны өдөр “Гаалийн эрсдэлийн менежмент” сэдвээр хоёр цагийн хичээл заасан (“1.Гаалийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, 2.Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын схем, 3.Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт, 4.Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийн хэрэгжилт” зэрэг илтгэл-танилцуулга).<br>5.ГЕГ-ын дэргэдэх Сургалтын төвд зохион байгуулагдаж буй “Гаалийн бүртгэгдсэн мэргэжилтний эрх сунгах давтан шатны сургалт”-ын хөтөлбөр, төлөвлөгөөнд заасны дагуу 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр “Гаалийн эрсдэлийн менежмент” сэдвээр хичээл заасан (“1.Гаалийн байгууллагын үйл ажиллагааны зохион байгуулалт, 2.Эрсдэлийн удирдлагад суурилсан гаалийн хяналтын схем, 3.Гаалийн байгууллагын эрсдэлийн удирдлагын зохион байгуулалт, 4.Гаалийн Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөрийн хэрэгжилт” зэрэг илтгэл-танилцуулга). | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Гаалийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | Сургалтад хамрагдсан байна. | Мэдээллийн цаг болон бусад газар, хэлтсээс зохион байгуулагддаг сургалтад хамрагдсан. | 01.01-06.10 | 100 |
| 2. | Гаалийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | ***Сургалт, зөвлөгөөн:***<br>- БНСУ-ын консорциумаас “хиймэл оюун ухаанд суурилсан дэвшилтэд технологийг нэвтрүүлэх замаар монголын гаалийн шинэчлэлийг бэхжүүлэх төсөл”-ийн уулзалтад оролцсон.<br>- ГЕГ-ын даргын 2025.04.16-ны өдрийн А/152 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг хангуулах судалгаа, дүн шинжилгээний ажлын хэсэг”-ээс зохион байгуулсан “Мэдээллийн дүн шинжилгээ” Power BI сургалтад хамрагдсан. | 2024.01.02-2024.06.10 | 100% |
| 3. | Төрийн байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах заалтын дагуу Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | - | 50% | Монгол бичгийн ахисан түвшний мэдлэгээ гүнзгийрүүлэн хувиараа судалж байна. | 2024.01.02-2024.06.10 | 100% |

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ .................................... У.ОТГОНБАЯР

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ У.ОТГОНБАЯРЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ,
ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар
Нэгжийн нэр: Эрсдэлийн удирдлагын хэлтэс

## 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. “ХУУЛЬ ЁСНЫ ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Гаалийн хяналтад эрсдэл тооцсон байдал | 58 | 9 | 67 | |
| 2 | Хууль сахилтын удирдлагын хэрэгжилтийг хангах | 55 | 8 | 63 | |
| 3 | Гадаад худалдааг хөнгөвчлөх | 54 | 6 | 60 | |
| 4 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58 | 7 | 63 | |
| 5 | Үүрэг, даалгаврын биелэлт | 58 | 8 | 66 | |
| 6 | Байгууллагын үйл ажиллагааг үндэсний болон олон улсын стандартад нийцүүлэх | 55 | 6 | 61 | |
| 7 | Гаалийн хяналтад эрсдэл тооцох системийг боловсронгуй болгох ажлын хэрэгжилт | 59 | 10 | 69 | |
| **Зорилт 2. “НОГООН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИЖ, ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ” зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт** | | | | | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоомж, тогтоол шийдвэр, эрхзүйн актын хэрэгжилт | 55 | 8 | 67 | |
| 2 | Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал | 55 | 6 | 61 | |
| 3 | Ажлын цаг ашиглалт | 56 | 8 | 64 | |
| 4 | Харьяа гаалийн газар, хороодод чиг үүргийн дагуу чиглэл, зөвлөмж хүргүүлж, удирдлага арга зүйгээр хангаж ажилласан байдал | 57 | 9 | 66 | |
| **Дундаж оноо:** | | | | 64.3 | |

## 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|

| | 1 | 2 | 3 | 4 |
|---|---|---|---|---|
| 1 | Арга хэмжээ 1. Гаалийн байгууллагаас зохион байгуулж буй сургалтад тухай бүр хамрагдах. | 100 | 15 | |
| 2. | Арга хэмжээ 2. Төрийн байгууллага албан хэргээ кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулах заалтын дагуу Монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлнэ. | 91 | 13.6 | |
| Дундаж оноо: | | | 14.3 | |

## 3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 6.2 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6.5 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 6.0 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6.4 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 6.0 | |
| **Дундаж оноо:** | | **6.2** | |

## 4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7.0 |
| 2 | Багаар ажиллах | 7.4 |
| 3 | Харилцаа | 7.1 |
| **Дундаж оноо: 7.2** | | |

## 5. Гүйцэтгэлийн үнэлгээ

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | *65.3* |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 14.3 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.2 |

| | | |
|---|---|---|
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Хамт олны үнэлгээ)* | 7.2 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | - |
| **Нийт оноо =94.6**<br>(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | | **93** |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***
Эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Д.Цэндсүрэн)

2025.06.10 (огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***
Гаалийн улсын байцаагч .............................. (У.Отгонбаяр)

2025-VI-10 (огноо)

***Үнэлгээг хянасан:***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***
Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч .............................. (Г.Энхтайван)

2025.06.25 (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***
Хүний нөөцийн хэлтсийн Гаалийн улсын ахлах байцаагч .............................. (Ө.Тэгшээ)

2025. 06. 25 (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***

Гаалийн ерөнхий газрын дарга .............................. (Р.Отгонжаргал)

2025. 06. 25.